



“Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ
Судалгаа, хөгжил, чанарын удирдлагын төв



2021 он

**УЛААНБААТАР ХОТОД ҮЙЛ АЖИЛЛАГАА
ЯВУУЛЖ БУЙ БҮТЦИЙН НЭГЖИЙН
АЖИЛТНУУДЫН ЗОРЧИХ УРСГАЛЫГ
ТОДОРХОЙЛОХ СУУРЬ СУДАЛГАА**



УЛААНБААТАР

НЭГ. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ	2
1.1 Судалгааны зорилго:.....	2
1.2 Судалгааны аргачлал:.....	2
1.3 Судалгааны хамрах хүрээ:.....	2
1.4 Мэдээ, мэдээллийг боловсруулах:.....	2
ХОЁР. СУДАЛГААНЫ ҮР ДҮН.....	3
2.1 Судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээлэл	3
2.3 ТӨВ БАЙРАНД БАЙРЛАН АЖИЛЛАДАГ ХЭЛТЭС, ТАСАГ	8
2.4 ЗОРЧИГЧ ТЭЭВРИЙН ТӨВҮҮД	
2.5 ТЕХНИК ХЯНАЛТЫН ТӨВҮҮД:.....	
2.6 ХӨСӨГ ТРЕЙД САЛБАР	
ГУРАВ. НЭГДСЭН ДҮГНЭЛТ	2

НЭГ. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

1.1 Судалгааны зорилго:

Улаанбаатар хотын түгжрэлийг бууруулах Засгийн газрын зорилтын хүрээнд Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй бүтцийн нэгжийн ажилчдын зорчих урсгалыг тодорхойлох судалгааны мэдээлэл цуглуулахад уг судалгааны зорилго оршино.

1.2 Судалгааны аргачлал:

Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй бүтцийн нэгжийн ажилчдаас судалгааг 14 хувьсах хэмжигдэхүүн бүхий тоон судалгааны аргаар тусгайлан боловсруулсан асуумжаар <https://docs.google.com/forms/> ашиглан судалгааны мэдээллийг цахим хэлбэрээр цуглуулсан. Судалгааны асуулгад 1 асуудлыг нээттэй бөглөхөөр оруулсан.

Googlemap ашиглан ажилдаа ирж буцахдаа нэг чиглэлд амьдардаг бусадтайгаа нэг тээврийн хэрэгслээр зорчих боломжтой ажилчдын судалгааг гаргасан болно.

1.3 Судалгааны хамрах хүрээ:

Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй бүтцийн нэгжийн нийт ажилтан албан хаагчид

1.4 Мэдээ, мэдээллийг боловсруулах:

Мэдээллийг Excel програмыг ашиглан статистикийн энгийн шинжилгээний аргыг ашиглан, үр дүнгийн шинжилгээ хийсэн.

ХОЁР. СУДАЛГААНЫ ҮР ДҮН


2.1 Судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээлэл

Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй 15 хэлтэс, тасаг, төвийн 322 ажилтан албан хаагч судалгаанд хамрагдсан нь нийт бүртгэлтэй ажилтны 78.5% -ийг эзэлж байна. Судалгаанд хамрагдаагүй 88 ажилтан буюу 21.5% нь ээлжийн амралттай, өвчтэй, чөлөөтэй, бусад шалтгааны улмаас судалгаанд хамрагдаагүй байна.

Судалгаанд хамрагдалтыг хэлтэс тасаг төвөөр нь доорх графикт харуулав.




Ажилтнуудын оршин суугаа хаяг:



Q 2. Та өөрийн харьяалагдах хэлтэс, тасаг, төвийн байршлыг сонгоно уу?

Судалгаанд хамрагдсан нийт ажилтны харьяалагдах байршлыг судлан үзэхэд 76 буюу 23.5% нь Төв байранд 18.6% нь Сонгионхайрхан салбар, 16.4% нь Хөсөг трейд салбарт байрлан ажилладаг байна.



Q 4. Та ажилдаа ирж буцахдаа ямар хэлбэрээр замын хөдөлгөөнд оролцдог вэ?

Судалгаанд хамрагдсан нийт ажилтны ажилдаа ирж буцахдаа замын хөдөлгөөнд оролцдог хэлбэрийг асуухад давхардсан тоогоо 260 нь хувийн автомашинаараа, 76 нь нийтийн тээврээр, 69 нь бусдын автомашинд дайгдах, 18 нь унадаг дугуйгаар гэх мэт хэлбэрээр ихэвчлэн зорчдог болох судлагааны үр дүнгээс харагдаж байна.




Q5. Та яагаад заавал хувийн автомашиныг сонгодог вэ?

Та ажилдаа ирж буцахдаа яагаад заавал хувийн автомашиныг сонгодог вэ гэсэн асуулгад 119 буюу 36.9% нь гэр бүлийн хэрэгцээнд зайлшгүй ашиглах шаардлага үүсдэг, 27.3% нь нийтийн тээврийн хүрэлцээ, орчин нөхцөл муу гэж хариулсан байна.




Q6. Яагаад нийтийн тээврийн үйлчилгээг сонгох боломжгүй байдаг вэ?

Ажилдаа ирж буцахдаа хувийн автомашинаар зорчдог ажилтнуудаас яагаад нийтийн тээврийн үйлчилгээг сонгох боломжгүй байдаг вэ гэсэн асуулгад 233 буюу 66.4% нь нийтийн тээврийн чиглэлийн хүртээмж муу, орчин нөхцөл тав тухгүй байдаг, тогтсон цаг хугацаандаа ирдэггүй гэсэн хариултууд давамгайлж байна.




Q8. Та ажилдаа унадаг дугуйгаар ирж очих боломжтой юу?

Ажилдаа ирж буцахдаа унадаг дугуйгаар зорчих боломжтой эсэх талаар асуухад 58.6% нь унадаг дугуйн зам байдаггүй, улирлын чанартай, унадаг дугуй унаж чаддаггүй гэж хариулжээ.




Q8. Та ажилдаа ирж буцахдаа хүүхдээ сургууль, цэцэрлэгт нь хүргэж өгч, авдаг уу?

Нийт судалгаанд хамрагдсан ажилтнуудын 175 буюу 54% нь ТИЙМ, 147 буюу 46% нь ҮГҮЙ гэж хариулжээ.




Q9. Танай хүүхдийн сургууль/цэцэрлэг байршил?

Ажилдаа ирж буцахдаа хүүхдээ сургууль, цэцэрлэгт нь хүргэж өгч авдаг гэж хариулсан ажилтнуудаас сургууль цэцэрлэгийн байршлын талаар асуухад 176 буюу 73% нь ГЭРТЭЙ ОЙР, 57 буюу 27% нь АЖИЛТАЙ ОЙР байдаг гэжээ.




Q11. Та ажилдаа ирж буцахдаа нэг чиглэлд амьдардаг бусадтайгаа нэг тээврийн хэрэгслээр зорчих боломжтой юу?

Судалгаанд хамрагдсан нийт ажилтнуудаас ажилдаа ирж буцахдаа нэг чиглэлд амьдардаг бусадтайгаа нэг тээврийн хэрэгслээр зорчих боломжтой эсэх талаар асуухад 85 буюу 27% нь ТИЙМ, 273 буюу 73% нь ҮГҮЙ гэж хариулжээ.




Q12. Та ажилчдын автобус үйлчилгээнд гаргавал дэмжих үү?

Судалгаанд хамрагдсан 322 ажилтнуудаас ажилчдын автобус үйлчилгээнд гаргавал дэмжих үү гэсэн санал асуулга авахад 279 буюу 87% нь ДЭМЖИНЭ, 43 буюу 13% нь ДЭМЖИХГҮЙ гэж хариулжээ.



Q13. Ажлын цагаар албан ажлаар замын хөдөлгөөнд оролцох шаардлага сард хэдэн удаа гардаг вэ?

Судалгаанд хамрагдсан нийт ажилтнуудын 39% ТОДОРХОЙЛОХ БОЛОМЖГҮЙ, 25% нь 1 – 2 удаа, 18% нь 3 – 6 удаа, 11% нь 10-аас дээш удаа ажлын цагаар албан ажлаар замын хөдөлгөөнд оролцох шаардлага гардаг гэж хариулжээ.



Q14. Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг арилгах чиглэлээр төрөөс ямар арга хэмжээ авахыг та хүсч байна вэ? гэсэн нээлттэй асуулгад дараах байдлаар хариулжээ. Үүнд:

- Нийтийн тээврийн чиглэлийн хүртээмж, зорчих эргэлтийг сайжруулах, үйлчилгээний нөхцлийг сайжруулах. / *тогтсон цаг хугацаандаа явдаггүй учир ажилд хоцрох шалтгаан болдог* /
- Сургууль, цэцэрлэгийн хүртээмжийг сайжруулж харьяа дүүрэгтээ буюу түр оршин сууж байгаа газартаа сургууль цэцэрлэгт хамрагдах боломжийг олгох, /*Сургалтын чанараас хамаарч хүүхдээ оршин сууж буй харьяаллын бус сургуульд буюу сургалтын чанар, багш хоёрыг сонгож сургууль сонгох нь их байна. Иймд боловсролын чанарыг тэгш байлгах*/
- Нийтийн тээврээр үйлчлүүлэх нь замын бөглөрөл, утааны бохирдол арилгах, мөн эдийн засгийн хэмнэлттэй гэх мэт хувь хүний сэтгэхүйг өөрчлөх арга хэмжээг авснаар иргэд нийтийн тээврээр үйлчлүүлж замын бөглөрөл арилгах боломжтой.
- Дугуйн зам болон авто замыг нэмэгдүүлэх, сайжруулах. Хиймэл түгжрэл үүсгэхгүй байх
- Бүх төрийн байгууллагууд ажилчдын унаатай болох шаардлагатай. Эхлэх цэг зүүн талд налайхаас эхлэх нь зүйтэй.
- Ажлын цагийг уян хатан болгох, Өглөө эрт ирсэн нь эрт тарах, орой ирсэн нь орой тарах, Нийтийн тээврийг үнэгүй болгож, дугаарын хязгаарлалтыг нэмэх
- Нийтийн тээврийн хүртээмж болон, замын нөхцөл байдал сайжруулах
- Нийтийн тээврийн нөхцөл цаг эргэлтийг сайжруулах
- Хүн ам ихээр төвлөрсөн ААНэгжүүдийг хотоос зайдуу гаргах
- Нарантуул худалдааны төвийг хотоос гаргах, Улсын томоохон сургуулиудыг хотоос гаргавал гэж боддог.
- Авто машины зорчих хэсгийг өргөтгөх, сургууль цэцэрлэг, ажилчдын автобус гаргах, дээд сургуулиудыг хотоос гаргаж орон нутагт төвлөрүүлэх г.м
- УБ хотын гол хэсгээр төмөр зам байдаг учир жнь: Нарантуул зах, Дүнжингарав худалдааны төвүүдийн ойролцоо нүхэн гарцууд нэмэх, мөн 4 замын уулзваруудад давхар зам хийх
- Төрийн үйлчилгээг цахимжуулах, цахим гарын үсэгт бүрэн шилжих, хүсэлтэд богино хугацаанд хариу өгдөг болгох, аливаа хурал зөвлөгөөнийг цахимаар хийж хэвших,
- Цэцэрлэгийн ажиллах цагийн хуваарийг уртасгах боломжийг төр засгаас авах - Сургуулийн автобусыг аль болох олон болгож хүүхдүүдийг автобусаар явах боломжийг бүрдүүлж, зардлыг төр хариуцах
- Зарим замуудын 1 дүгээр эгнээнд автомашин тавьж байгаагаас түгжрэл үүсч байгаа тул эдгээр автомашиныг ачих биш харин ачих хэмжээний мөнгөн торгууль тавьж богино хугацаанд төлүүлэх, хугацаандаа төлөөгүй жолооч нарын автомашиныг замын хөдөлгөөнд оролцуулахгүй байх арга хэмжээ авах, торгууль тавих ажлыг сайн дурын ажилтнууд болон орон тооны бус байцаагч цагдаагийн болон автотээврийн улсын байцаагч нар хариуцаж хийхээр эрх зүйн орчныг бүрдүүлэх,
- Нийтийн тээврийн парк шинэчлэлт хийж, тоо хэмжээг нэмэгдүүлэх, дүүргүүдийн алдслагдсан байршилд нийтийн тээврийн чиглэл нэмэх өөрчлөлт хийж, Улаанбаатар хотын замын хөдөлгөөний даац хэтэрсэн байгаа тул тээврийн хэрэслийг тэгш, сондгой тоогоор ангилж 7 хоногийн тэгш тоотой өдөр тэгш тоогоор төгссөн дугаартай тээврийн хэрэгслийг, сондгой тоотой өдөр сондгой тоогоор төгссөн дугаартай тээврийн хэрэгслийг хөдөлгөөнд оролцуулахад боломжтой гэж бодож байна.
- Нийтийн тээврийн хүрэлцээг хангах, маршрутыг судалгаан дээр үндэслэн оновчтой тогтоох, явган зорчигчийн болон ундаг дугуйн замыг нэмэгдүүлэх, Нисэх хотын төвийг холбосон замыг яармагийн гүүр сонсголонгийн гүүрний ачааллыг бууруулах, гүүр барих, нисэхээс 22 товчоо, эмээлтийг холбосон зам, гүүр барих. Ачааны машиныг хотоор дайрч гарах биш тойрч гардаг боломжтой болгох.

1. АЖИЛДАА ИРЖ БУЦАХДАА НЭГ ЧИГЛЭЛД АМЬДАРДАГ БУСАДТАЙГАА НЭГ ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛЭЭР ЗОРЧИХ БОЛОМЖТОЙ ЭСЭХ:

Судалгаанд хамрагдсан нийт ажилтнуудаас ажилдаа ирж буцахдаа нэг чиглэлд амьдардаг бусадтайгаа нэг тээврийн хэрэгслээр зорчих боломжтой эсэх талаар асуухад **85 буюу 27% нь ТИЙМ, 273 буюу 73% нь ҮГҮЙ** гэж хариулжээ. Боломжтой буюу ТИЙМ гэж хариулсан ажилтнуудын мэдээлэл дээр үндэслэн доорх судалгааг гаргав.

1.1 Төв байранд байрлан ажилладаг хэлтэс, тасаг



Ажилдаа ирж буцахдаа нэг чиглэлд амьдардаг бусадтайгаа нэг тээврийн хэрэгслээр зорчих боломжтой эсэх талаар санал асуухад судалгаанд хамрагдсан 82 ажилтны 62% нь ҮГҮЙ, 38% нь ТИЙМ гэж хариулжээ. Үүнээс боломжгүй гэж хариулсан ажилтнууд ажилдаа ирж буцах замдаа хүүхдээ сургууль, цэцэрлэгт нь хүргэж өгч, авах гэр бүлийн хүнээ ажилд нь хүргэж өгөх гэх мэт гэр бүлийн хэрэгцээний нийтлэг шаардлагуудтай байдаг байна.

Төв байранд үйл ажиллагаа явуулж буй Захиргаа, сургалт, хүний нөөцийн хэлтэс, Санхүү эдийн засгийн хэлтэс, Тээвэр зохицуулалтын хэлтэс, Хөдөлгөөн удирдлагын хэлтсийн **121** ажилтнаас **82** ажилтан судалгаанд хамрагджээ.

Нийт хамрагдсан ажилтны 42 нь хүүхдээ сургууль, цэцэрлэгт нь хүргэж өгч авдаг, 40 нь ажилдаа шууд ирдэг буюу ГЭР – АЖИЛ гэсэн маршруттай байдаг байна. Үүнээс нэг чиглэлд амьдардаг бусадтайгаа нэг тээврийн хэрэгслээр зорчих боломжтой гэж судалгаанд хамрагдсан 12 ажилтныг тээвэрлэх боломжтой тээврийн хэрэгслийн тоог доорх хүснэгтэд харуулав.

№	Ажилтан	Гэрийн хаяг, маршрут	Тээврийн хэрэгсэл тоо	Шаардлагатай тээврийн хэрэгсэл тоо
1	Б. Баатарцол	СБД, 8-р хороо	1	1
2	Б. Жанцансүрэн	СБД, 4-р хороо	1	
3	Б. Баянжаргал	СБД, 11-р хороо	1	
4	Э. Цолмон	ХУД, 11-р хороо	1	1
5	Жавхлан	ХУД, 15-р хороо	1	
6	Энхзаяа	ХУД, 16-р хороо	1	
7	Б. Мөнхцэцэг	ХУД, 2-р хороо	1	
8	Н.Дэлгэрмаа	ХУД, 1-р хороо	1	1
9	М.Агиймаа	БЗД, 7-р хороо	1	
10	Ө.Сэрсэндэмид	БЗД, 10-р хороо	1	
11	Ш.Чадраабал	БЗД, 14-р хороо	1	
12	Г.Баярмагнай	БЗД, 22-р хороо	1	
НИЙТ			12	3

Жишээ нь:



1.2 Зорчигч тээврийн төвүүд

Сонгинохайрхан зорчигч тээврийн төв

Сонгинохайрхан ЗТТ болон БЗЗТТ-ын ажилтнуудаас нэг чиглэлд амьдардаг бусадтайгаа нэг тээврийн хэрэгслээр зорчих боломжтой гэж судалгаанд хамрагдсан 8 ажилтныг судлан шаардлагатай тээврийн хэрэгслийн тоог доорх хүснэгтэд харуулав:

№	Ажилтан	Гэрийн хаяг, маршрут	ТХ тоо	Шаардлагатай ТХ тоо
1	Ц.Цэцэг-Ундрал	БГД, 3-р хороо	1	1
2	Г.Ганчимэг	БГД, 8-р хороо	1	
3	Ч.Чимгээ	БГД, 5-р хороо	1	
4	Б.Лхамсүрэн	БГД, 2-р хороо	1	
5	Б.Баярмагнай	БЗД, 25-р хороо	1	1
6	Г.Батцоож	БЗД, 13-р хороо	1	
7	Б.Насанжаргал	БЗД, 6-р хороо	1	
8	А.Оюун	БЗД, 4-р хороо	1	
НИЙТ			11	2

Баянзүрх зорчигч тээврийн төв

№	Ажилтан	Гэрийн хаяг, маршрут	ТХ тоо	Шаардлагатай ТХ тоо
1	Ц.Бямбацогт	Сүхбаатар дүүрэг, 9-р хороо	1	1
2	Э.Энхтуул	Сүхбаатар дүүрэг, 15-р хороо	1	
3	Н.Баярмагнай	Баянгол дүүрэг, 15-р хороо	1	
4	Т.Алтанхуяг	Баянгол дүүрэг, 2-р хороо	1	1
5	Б.Баттуул	Баянгол дүүрэг, 4-р хороо	1	
6	Д.Баатарсүрэн	Чингэлтэй дүүрэг, 3-р хороо	1	
НИЙТ			6	2

1.3 Техникийн хяналтын төвүүд

Баянзүрх ТХТ болон Сонгинохайрхан ТХТ-ын ажилтнуудаас нэг чиглэлд амьдардаг бусадтайгаа нэг тээврийн хэрэгслээр зорчих боломжтой гэж судалгаанд хамрагдсан 5 ажилтныг судлан шаардлагатай тээврийн хэрэгслийн тоог доорх хүснэгтэд харуулав:

Баянзүрх техник хяналтын үзлэгийн төв

№	Ажилтан	Гэрийн хаяг	ТХ тоо	Шаардлагатай ТХ тоо
1	Т.Мөнхцэцэг	Чингэлтэй дүүрэг	1	1
2	Н.Мөнхочир	Чингэлтэй дүүрэг	1	
3	Б.Солонго	Баянгол дүүрэг	1	1
4	С.Сэр-Од	Баянгол дүүрэг	1	
5	Г.Батмөнх	СХД	1	
НИЙТ			5	2

Сонгинохайрхан техник хяналтын үзлэгийн төв

№	Ажилтан	Гэрийн хаяг	ТХ тоо	Шаардлагатай ТХ тоо
1	Ж.Доржготов	Баянзүрх дүүрэг	1	1
2	Д.Доржсүрэн	Сонгинохайрхан дүүрэг	1	
3	М.Мөнхсүх	Сонгинохайрхан дүүрэг	1	
4	С.Оюун-Эрдэнэ	Сонгинохайрхан дүүрэг	1	1
5	Б.Цэлмэг	Баянгол дүүрэг	1	
6	Ч.Баяндалай	Баянгол дүүрэг	1	
НИЙТ			6	2

1.4 ХЭСӨГ ТРЕЙД

Хөсөг трейд салбарт байрлан ажилладаг Судалгаа, хөгжил, чанарын удирдлагын төв, Техникийн хяналтын хэлтэс, Баянгол техник хяналтын үзлэгийн төвийн 53 ажилтнаас 43 ажилтан судалгаанд хамрагдсан байна. Тэдгээрийн ажилдаа ирж буцах маршрутыг судлан үзэхэд 16 ажилтан хүүхдээ сургууль цэцэрлэгт нь хүргэж өгч, авах гэж замын хөдөлгөөнд хувийн автомашинтайгаа оролцдог бол 27 ажилтан ажилдаа шууд ирж буцдаг байна. Үүнээс 24 ажилтан хувийн автомашин, 3 ажилтан нийтийн тээврээр зорчдог. Нэг чиглэлд амьдардаг бусадтайгаа нэг тээврийн хэрэгслээр зорчих боломжтой эсэх талаар санал асуулга асуухад боломжтой гэж хариулсан 9 ажилтныг судлан шаардлагатай тээврийн хэрэгслийн тоог доорх хүснэгтэд харуулав

№	Ажилтан	Гэрийн хаяг	ТХ тоо	Шаардлагатай тээврийн хэрэгсэл тоо
3	Г.Ариунболд	Баянгол дүүрэг	1	1
4	Д.Баттөмөр	БГД, 6-р хороо	1	
5	Б.Хишигболд	Баянгол дүүрэг	1	
6	Б.Баярсайхан	Баянзүрх дүүрэг	1	1
7	Л.Чойжилсүрэн	Баянзүрх дүүрэг	1	
8	Б.Нармандах	Баянзүрх дүүрэг	1	
9	Г.Хулан	БЗД, 24-р хороо	1	
Нийт			9	2

Ажилдаа ирж буцахдаа нэг чиглэлд амьдардаг бусадтайгаа нэг тээврийн хэрэгслээр зорчих боломжтой эсэх талаар санал асуухад судалгаанд хамрагдсан нийт ажилтны 273 буюу 73% боломжгүй, 49 буюу 15% нь боломжтой гэж хариулжээ. Боломжтой гэж хариулсан 49 ажилтны мэдээлэл дээр үндэслэн тооцож дээрх судалгааг гаргав.

№	ХЭЛТЭС, ТАСАГ, ТӨВ	Тээврийн хэрэгслийн тоо	Шаардлагатай тээврийн хэрэгслийн тоо
1	ТӨВ БАЙР / ЗСХНХ, СЭЗХ, ХУХ, ТЗХ /	12	3
2	Сонгинохайрхан ЗТТ	11	2
3	Баянзүрх ЗТТ	6	2
4	Сонгинохайрхан ТХТ	6	2
5	Баянзүрх ТХТ	5	2
6	Хөсөг трейд салбар / СХЧУТ, ТХХ, БГТХТ /	9	2
НИЙТ		49	13 ↓

2. СЭЛГЭН АЖИЛЛАХ БОЛОМЖ

2.1 Зорчигч тээврийн төвүүд

№	Ажилтан	Албан тушаал	Гэрийн хаяг	№	Ажилтан	Гэрийн хаяг	Албан тушаал
БАЯНЗҮРХ ЗОРЧИГЧ ТЭЭВРИЙН ТӨВ				СОНГИНОХАЙРХАН ЗОРЧИГЧ ТЭЭВРИЙН ТӨВ			
1	У. Батхүү	Дарга	ХУД, 2-р хороо	1	Ц.Цэцэг-Ундрал	БГД, 3-р хороо	Дарга
2	Ц.Бямбацогт	Чанарын менежер	СБД, 9-р хороо	2	Б.Баярмагнай	БЗД, 25-р хороо	Чанарын менежер
3	Н.Баярмагнай	Ахлах нягтлан бодогч	БГД, 15-р хороо	3	Г.Ганчимэг	БГД, 8-р хороо	Ахлах нягтлан бодогч
4	Д. Баатарсүрэн	Нягтлан бодогч	ЧД, 3-р хороо	4	Н.Сайнбаяр	БГД, 2-р хороо	Нягтлан бодогч
5	С. Мөнгөнцэцэг	Нягтлан бодогч	ХУД, 15-р хороо	5	Э.Энх-Ундраа	СХД 4-р хороо	Нягтлан бодогч
6	Т.Цэцэгээ	Нярав	БЗД, 15-р хороо	6	Х.Ариунсүвд	БГД, 18-р хороо	Нярав, бичиг хэрэг
Тээвэр зохицуулагч							
1	П.Саранцэцэг	Тээвэр зохицуулагч	СХД, 4-р хороо	1	О.Баяраа	БЗД, 14-р хороо	Тээвэр зохицуулагч
2	Э.Цолмон	Тээвэр зохицуулагч	СХД, 37-р хороо	2	Г.Батцоож	БЗД, 10-р хороо	Тээвэр зохицуулагч
3	Ш.Эрдэнэбат	Тээвэр зохицуулагч	СХД, 13-р хороо	3	Б.Насанжаргал	БЗД, 6-р хороо	Тээвэр зохицуулагч
4	М. Мөнхсайхан	Тээвэр зохицуулагч	СХД, 30-р хороо	4	Ч. Чулуун - Эрдэнэ	БЗД, 6-р хороо	Тээвэр зохицуулагч
5	М.Одгэрэл	Тээвэр зохицуулагч	БЗД, 26-р хороо	5	Г. Батцоож	БЗД, 1-р хороо	Тээвэр зохицуулагч
6	Б.Оюунномин	Тээвэр зохицуулагч	БЗД, 8-р хороо	6	Л. Цэрэндолгор	БГД, 19-р хороо	Тээвэр зохицуулагч
7	Э.Юрэндорж	Тээвэр зохицуулагч	БЗД, 8-р хороо	7	Д. Цогтгэрэл	БГД, 11-р хороо	Тээвэр зохицуулагч
8	Б.Доржсүрэн	Тээвэр зохицуулагч	БЗД, 1-р хороо	8	Д. Гандэлгэр	БГД, 5-р хороо	Тээвэр зохицуулагч
9	Б.Билгүүн	Тээвэр зохицуулагч	БЗД, 25-р хороо	9	Б.Энхбилэг	СХД 3-р хороо	Тээвэр зохицуулагч
10	Д.Жавгаралмаа	Тээвэр зохицуулагч	БЗД, 17-р хороо	10	О.Сэлэнгэсайхан	СХД, 19-р хороо	Тээвэр зохицуулагч
11	Г. Гансүх	Тээвэр зохицуулагч	БЗД, 14-р хороо	11	Ө.Нандинцэцэг	СХД, 38-р хороо	Тээвэр зохицуулагч
12	З.Мөнхбаяр	Тээвэр зохицуулагч	БГД, 12-р хороо	12	О.Сэлэнгэсайхан	СХД, 19-р хороо	Тээвэр зохицуулагч
13	О.Энхцэцэг	Тээвэр зохицуулагч	БГД, 3-р хороо	13	Т.Пүрэвдорж	СХД, 19-р хороо	Тээвэр зохицуулагч
14	Т.Алтанхуяг	Тээвэр зохицуулагч	БГД, 2-р хороо	14	В. Болорчимэг	СХД, 15-р хороо	Тээвэр зохицуулагч
15	О.Наранцэцэг	Тээвэр зохицуулагч	БГД, 18-р хороо	15	Д. Ариунаа	СХД, 15-р хороо	Тээвэр зохицуулагч
16	Э.Алтанзул	Тээвэр зохицуулагч	БГД,	16	Г. Эрдэнэбаяр	СХД, 3-р хороо	Тээвэр зохицуулагч
17	Д.Цэцэгээ	Тээвэр зохицуулагч	ХУД, 7-р хороо	17	Л. Ачитмаа	СХД, 29-р хороо	Тээвэр зохицуулагч
				18	О. Сэлэнгэсайхан	СХД, 19-р хороо	Тээвэр зохицуулагч
				19	Г. Төгөлдөр	СХД, 3-р хороо	Тээвэр зохицуулагч
				20	Л. Отгонжаргал	СХД, 13-р хороо	Тээвэр зохицуулагч
				21	А. Нандин - Эрдэнэ	СХД, 26-р хороо	Тээвэр зохицуулагч
				22	Р. Дорж	СХД, 4-р хороо	Тээвэр зохицуулагч
				23	Т. Пүрэвдорж	СХД, 19-р хороо	Тээвэр зохицуулагч
Тасалбр түгээгч							
1	Э.Энхтуул	Тасалбр түгээгч	БЗД, 8-р хороо	1	А.Оюун	БЗД, 4-р хороо	Тасалбар түгээгч
2	Б.Баттуул	Тасалбр түгээгч	БЗД, 8-р хороо	2	Ч.Чимгээ	БГД, 5-р хороо	Тасалбар түгээгч
3	М.Нандиннавч	Тасалбр түгээгч	БЗД, 22-р хороо	3	Б.Лхамсүрэн	БГД, 2-р хороо	Тасалбар түгээгч
4	М.Тогтох	Тасалбр түгээгч	БГД, 15-р хороо	4	Ж. Оюунжаргал	БГД, 3-р хороо	Тасалбар түгээгч
5	С.Уранчимэг	Тасалбр түгээгч	БГД, 4-р хороо	5	Б. Лхамсүрэн	БГД, 8-р хороо	Тасалбар түгээгч
6	З.Балжмаа	Тасалбр түгээгч	СБД, 15-р хороо	6	Д. Жаргал	СХД, 3-р хороо	Тасалбар түгээгч
7	Г.Одонтуяа	Тасалбр түгээгч	СХД, 2-р хороо	7	Б. Цацралт	СХД, 9-р хороо	Тасалбар түгээгч

БЗЗТТ – 4 / ТЗ/, 1 / Тасалбар түгээгч

СХЗТТ – 4 / ТЗ/, 1 / Тасалбар түгээгч /

2.2 Техникийн хяналтын төвүүд

№	Ажилтан	Албан тушаал	Гэрийн хаяг	№	Ажилтан	Гэрийн хаяг	Албан тушаал	№	Ажилтан	Гэрийн хаяг	Албан тушаал
Баянзүрх ТХТ				Баянгол ТХТ				Сонгинохайрхан ТХТ			
1	Б.Солонго	Ахлах нягтлан бодогч	БГД,6-р хороо	1	Ц.Уранчимэг	Баянзүрх дүүрэг 15-р хороо	Ахлах нягтлан бодогч	1	Ш.Нямсод	БЗД 26-р хороо	ТХУ техникч
2	С.Сэр-Од	ТХУ инженер	БГД, 18-р хороо	2	Ч.Онон	Баянзүрх дүүрэг 15-р хороо	ТХУ инженер				
3	Б.Баттөр	ТХУ техникч	Баянгол дүүрэг 15-р хороо	3	Б.Баярсайхан	Баянзүрх дүүрэг 11-р хороо	ТХУ техникч				
4	Ш.Баясгалан	ТХУ инженер	Сонгинохайрхан дүүрэг, 29-р хороо						Ж.Доржготов	БЗД, 8-р хороо	Техникийн хяналтын үзлэгийн инженер
				4	Э.Золбоо	Сонгинохайрхан дүүрэг 18-р хороо	Техникийн хяналтын үзлэгийн инженер		С.Соёл-Эрдэнэ	БГД 6-р хороо	
				5	О.Ганчулуун	Сонгинохайрхан дүүрэг 12 -р хороо			Д.Түвшинтөгс	БГД,6-р хороо	
				6	П.Баясгалан	Сонгинохайрхан дүүрэг 4-р хороо	Техникийн хяналтын үзлэгийн техникч		Б.Цэлмэг	ТХУ техникч	
				7	Ж.Бямбацогт	СХД, 12-р хороо			Ч.Баяндалай		Баянгол дүүрэг 11-р хороо

БЗТХТ - 1 / ахлах нягтлан бодогч /, 2 / ТХУ инженер /, 1 / Техникч /

БГТХТ - 1 / ахлах нягтлан бодогч /, 2 / ТХУ инженер /, 1 / Техникч /

СХТХТ - 3 / ТХУ инженер /, 2 / Техникч /


3. АЖИЛЧДЫН АВТОБУС ГАРГАХ БОЛОМЖ / ЧИГЛЭЛ, МАРШРУТ /

Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй бүтцийн нэгжийн ажилтнуудаас ажилчдын автобус үйлчилгээнд гаргавал дэмжих эсэх талаар санал асуулга авахад 279 буюу 87% нь дэмжинэ гэж хариулжээ. Бүтцийн нэгжийн 408 ажилтнаас өдөрт дунджаар 300 ажилтан зорчих боломжтой гэж тооцон ажилчдын автобус гарган тээвэрлэх боломж болон чиглэл маршрутыг судлан дараах 3 чиглэлийг үйлчилгээнд гаргах шаардлагатай гэж үзэж байна. Хэвтээ тэнхлэгийн дагуу төв замаар ажилчдын автобус гаргахаар төлөвлөв.



1. “СОНГИНОХАЙРХАН – БАЯНЗҮРХ” чиглэл

Сонгинохайрхан – Баянзүрх чиглэлд замын хөдөлгөөнд оролцдог ажилтнуудыг баруунаас зүүн чиглэлд төв зам дагуу тээвэрлэхэд 113 ажилтан тээвэрлэх боломжтой байна. Дэлгэрэнгүй мэдээллийг доорх хүснэгтэд харуулав.



2. “БАЯНЗҮРХ – СОНГИНОХАЙРХАН” чиглэл

Баянзүрх – Сонгинохайрхан чиглэлд замын хөдөлгөөнд оролцдог ажилтнуудыг зүүнээс баруун чиглэлд төв зам дагуу тээвэрлэхэд 135 ажилтан тээвэрлэх боломжтой байна.



Сонгинохайрхан – Баянзүрх , Баянзүрх – Сонгинохайрхан чиглэлд зорчих боломжтой ажилтнуудын мэдээллийг доорх хүснэгтэд дэлгэрэнгүй харуулав.

Дүүрэг	Хөсөг трейд			Төв байр				
	СХЧУТ	Баянгол техник хяналтын үзлэгийн төв	Техник хяналт	Хөдөлгөөн удирдлагын хэлтэс	Ачаа тээвэр	Зорчигч тээврийн тасаг	Захиргаа сургалт хүний нөөц	Санхүү эдийн засгийн хэлтэс
Баянгол	8	4	3	11	1	3	6	3
Баянзүрх	5	8	3	13	2	2	9	7
Сонгинохайрхан	4	7	1	5	1	0	4	1
Сүхбаатар	1	1	0	4	2	1	3	1
Хан-Уул	2	6	3	11	0	1	7	1
Чингэлтэй	0	1	0	1	0	1	4	0
СХД-БЗД	4	7	1	20	4	4	13	5
БЗД - СХД	6	9	3	17	4	3	12	8
Дүүрэг	Цирк	Тэнгэр плаза	БЗТХУТ	Драгон төв		Сонсогolon	Нийт	
	Мэдээлэл технологийн хэлтэс	Баянзүрх зорчигч тээврийн төв	Баянзүрх техник хяналтын үзлэгийн төв	Авто үйлчилгээ	Сонгинохайрхан зорчигч	Сонгинохайрхан техникийн хяналтын үзлэгийн төв		
Баянгол	4	7	4	4	10	4		
Баянзүрх	4	12	15	0	6	2		
Сонгинохайрхан	1	5	3	2	22	15		
Сүхбаатар	1	1	2	1	0	2		
Хан-Уул	1	6	3	1	0	8		
Чингэлтэй	1	1	2	0	1	0		
СХД-БЗД	6	25	24					113
БЗД - СХД	5			7	38	23		135

3. “ХАН-УУЛ – БАЯНЗҮРХ” чиглэл

Хан-Уул – Баянзүрх чиглэлд нийт 30 ажилтан тээвэрлэх боломжтой бөгөөд төв байранд 19 ажилчин буух бол эцсийн цэг буюу Баянзүрх техник хяналтын үзлэгийн төвд ажилдаг 3 ажилчин байна. Энэ чиглэлд 1 дунд оврын автобус шаардлагатай гэж үзэж байна.

Дүүрэг	Төв байр					Цирк	Тэнгэр плаза	БЗТХУТ	Нийт
	ХУХ	АТ	ЗТ тасаг	ЗСХНХ	СЭЗХ				
Хан-Уул	11	0	1	7	1	1	6	3	30

АЖИЛЧДЫН АВТОБУС ГАРГАХ БОЛОМЖ / ЧИГЛЭЛ, МАРШРУТ /

Чиглэл / маршрут /	Ажилтны тоо	Шаардлагатай автобус тоо	Нийт тээврийн хэрэгслийн тоо / судалгаанд хамрагдсан/
СОНГИНОХАЙРХАН – БАЯНЗҮРХ	113	2 /45 хүний суудалтай/	260
БАЯНЗҮРХ - СОНГИНОХАЙРХАН	135	2 /45 хүний суудалтай/	
ХАН – УУЛ - БАЯНЗҮРХ	30	1 /45 хүний суудалтай/	
Нийт	278	5	

ГУРАВ. НЭГДСЭН ДҮГНЭЛТ

Энэхүү судалгаанд Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй 15 хэлтэс тасаг, төвийн 410 ажилтан судалгаанд хамрагдахаас 322 буюу 78% нь судалгаанд хамрагдсан бол 88 буюу 21.5% өвчтэй, чөлөөтэй, ээлжийн амралттай, бусад шалтгааны улмаас судалгаанд хамрагдаагүй байна. Судалгааны мэдээллийг 14 хувьсах хэмжигдэхүүн бүхий тоон судалгааны аргаар тусгайлан боловсруулсан асуумжаар <https://docs.google.com/forms/> ашиглан мэдээллийг цуглуулан ажиллаа.

Судалгааны ажлын хүрээнд дараах санал зөвлөмжийг хүргүүлж байна.

ДОТООДОД АВАХ АРГА ХЭМЖЭЭ:

1. Ажилчдын автбусыг туршилтаар /түрээс/ явуулах саналыг ажилчдын 279 буюу 87% нь дэмжиж байна. Ингэснээр 260 тээврийн хэрэгслийг замын хөдөлгөөнд оролцооос сэргийлэн 5 автобус 3 чиглэлд үйлчилгээнд гаргах
2. Ижил ажлын байранд ажиллаж байгаа 24 ажилтныг амьдарч байгаа харьяаллын дагуу шилжүүлэн ажиллуулах.
3. Үйлдвэрийн газрын дотоод хурал зөвлөгөөн, албан бичиг, түүний баримтжуулах явдал цахим технологийг идэвхитэй ашиглах. Энэ хүрээнд салбар тус бүр дээр цахим хурлын төхөөрөмж суурилуулах, эрх бүхий албан тушаалтнуудад цахим гарын үсгийн хэрэглээг дэмжих.
4. Ажилдаа ирж буцахдаа боломжит нэг автомашинаар явах, ундаг дугуйгаар явах, явганаар явах явдлыг дэмжих, аян зохион байгуулах, урамшуулал олгох.
5. Ажлын цагийг уян хатан /өглөө эрт ирсэн нь оройн эрт харих/ хүний нөөцийн зохицуулалт хийх.
6. “НЭГ ЧИГЛЭЛД - НЭГ МАШИН” аян эхлүүлэх.

ГАДААДАД АВАХ АРГА ХЭМЖЭЭ:

1. Ажилтны оршин суугаа /түр оршин суугаа/ хаягийн дагуу хүүхдийн сургууль, цэцэрлэгт хамрагдах боломжийг олгох талаар холбогдох төрийн захиргааны байгууллагад хандах.
2. Боловсролын байгууллагын ажиллах цагийн хуваарийг уртасгах боломжийг төр засгаас авах.
3. Сургуулийн автобусыг аль болох олон болгож хүүхдүүдийг автобусаар явах боломжийг бүрдүүлэх, зардлыг төр хариуцах.
4. Нийтийн тээврийн чиглэлийн хүртээмж, үйлчилгээний нөхцлийг сайжруулах.
5. Явган хүний зам дугуйн зам,

Төсгөв.